

**НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР БАЙГУУЛАХ ТУХАЙ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,

**НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГА
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2025 оны 08 сарын 14 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГА

I дүгээр зүйл

Тодорхойлолт

Энэхүү Хэлэлцээрийн зорилгын хүрээнд дараах тодорхойлолтыг ашиглана. Үүнд:

- a) "ХХААБ", эсхүл "Байгууллага" гэж НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагыг;
- b) "Улс" гэж Монгол Улсыг;
- c) "Засгийн газар" гэж Монгол Улсын Засгийн газрыг;
- d) "Төлөөлөгчийн газар" гэж ХХААБ-ын Монгол Улс дахь төлөөлөгчийн газрыг;
- e) "Суурин төлөөлөгч" гэж Монгол Улс дахь Төлөөлөгчийн газрын тэргүүн, эсхүл Төлөөлөгчийн эзгүйд дотоод журмын дагуу Ерөнхий захирлаас албан ёсоор эрх олгосон үүрэг гүйцэтгэгчийг;
- f) "Ерөнхий захирал" гэж НҮБ-ын ХХААБ-ын Ерөнхий захирал, эсхүл үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн үед тус үүргийг гүйцэтгэх албан тушаалтныг;
- g) "ХХААБ-ын гишүүд" гэж НҮБ-ын ХХААБ-ын гишүүн улс, гишүүн байгууллагыг;
- h) "Конвенц" гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1947 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр баталсан НҮБ-ын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцыг;
- i) "Ажилтан" гэж Иргэншил, оршин суугаа байдал, олон улс, эсхүл орон нутгийн хэмжээнд сонгон шалгаруулсан байхаас үл хамааран, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Боловсон хүчний Дүрэм, журмын дагуу Ерөнхий захирлын томилсон бүх ажилтан, зөвлөхүүдийг ойлгоно. Үүнд 1959 оны 11 дүгээр сарын НҮБ-ын ХХААБ-ын Бага хурлын 10 дугаар чуулганаар баталсан 71/59 тоот тогтоолд заасны дагуу орон нутагт ба цагаар ажилд авсан хүмүүс хамаарахгүй;
- j) "Алба гүйцэтгэгч мэргэжилтэн" гэж ХХААБ-ын ажилтнуудаас бусад, ХХААБ-ын хороодод ажиллаж буй, эсхүл ХХААБ-ын даалгавраар үүрэг гүйцэтгэж буй хүмүүсийг;
- к) "Боловсон хүчин" гэж ХХААБ-ын ажилтнууд, алба гүйцэтгэгч мэргэжилтнүүд болон ХХААБ-д албан үүргийн дагуу томилогдсон бусад хүмүүсийг хамруулан;



l) "Хөрөнгө" гэж VII дугаар зүйлд дурдсан ХХААБ-ын өмчлөлд байгаа, эсхүл ХХААБ-ын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ХХААБ-ын эзэмшил, удирдлага, ашиглалтад байгаа бүх төрлийн хөрөнгө, сан, орлого болон бусад эд хөрөнгийг;

m) "Барилга байгууламж" гэж ХХААБ-ын байнгын болон түр хугацаагаар эзэмшиж буй барилга, барилгын хэсэг, түүнчлэн тухайн улсад ХХААБ-ын чиг үүрэг, зорилготой холбоотойгоор олгогдсон, эзэмшиж, эсхүл ашиглаж буй газар, барилга байгууламж, суурилуулалт, тоног төхөөрөмжийг;

n) "Архив" гэж ХХААБ эзэмшиж, эсхүл хадгалж буй бүх төрлийн баримт бичиг, үүнд захидал харилцаа, баримт бичиг, хэвлэл нийтлэл, гар бичмэл, гэрэл зураг, дүрс бичлэг, дуу бичлэг, компьютерын өгөгдлийн файлууд, программ хангамж зэргийг хязгаарлалтгүйгээр хамруулан;

o) "Үйл ажиллагаа" гэж тухайн улсад ХХААБ-ын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүх төрлийн үйл ажиллагаа, арга хэмжээг ойлгоно;

p) "Талууд" гэж ХХААБ болон Монгол Улсын Засгийн газрыг хамруулан ойлгоно.

II дугаар зүйл

Хуулийн этгээдийн эрх

ХХААБ нь хууль эрх зүйн дараах эрх болон чадамжтай байна. Үүнд:

a) Гэрээ байгуулах;

b) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө худалдан авах, захиран зарцуулах;

c) Шүүхийн үйл ажиллагаанд оролцох.

III дугаар зүйл

Конвенцын хэрэгжилт

1. Засгийн газар нь ХХААБ, түүний өмч, сан, хөрөнгө, мөн тус байгууллагын ажилтнууд болон алба гүйцэтгэгч мэргэжилтнүүдэд энэхүү Конвенцод заасан эрх ямба, дархан эрхийг олгоно.

2. Мөн Засгийн газар нь ХХААБ болон түүний ажилтанд энэхүү Хэлэлцээрт тусгагдсан эрх ямба, дархан эрхийг олгоно.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2025 оны 08 сарын 12 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

IV дүгээр зүйл

ХХААБ тус Улсад ажиллах байдал

1. Батлагдсан төсвийн хүрээнд ХХААБ нь тухайн Улсад Суурин төлөөлөгч томилох бөгөөд Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад ажилтнуудыг томилон ажиллуулна.
2. Шаардлагатай гэж үзвэл, ХХААБ нь төлөөлөгчийн газарт томилогдсон бүх ажилтнуудын холбогдох мэдээллийг Засгийн газарт өгнө. Үүнд тухайн ажилтнууд болон тэдний гэр бүлийн гишүүдийн нэрс, мөн тэдний статусын өөрчлөлтийн талаарх мэдээлэл хамаарна. Түүнчлэн, төлөөлөгчийн газар нь ХХААБ-ын үйл ажиллагааг зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад ажилтнуудыг ажиллуулна.
3. ХХААБ нь Монгол Улсын Яаманд ХХААБ-ын бусад ажилтнуудын нэрс болон эдгээр хувь хүмүүсийн статусын өөрчлөлтүүдийн тухай мэдэгдэнэ.
4. ХХААБ-ын ажилтнуудад Засгийн газраас, зохистой гэж үзвэл, энэхүү хэлэлцээрийн хүрээнд тэдний статусыг баталгаажуулсан түр гэрчилгээ, эсхүл тусгай үнэмлэх олгоно.

V дугаар зүйл

Үйл ажиллагааны бие даасан байдал болон ХХААБ-ын ажилтан

1. ХХААБ нь тус Улсад үйл ажиллагаа явуулах, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай ажилтнууд болон бусад боловсон хүчинг төлөөлөгчийн газарт томилохдоо үйл ажиллагааны бие даасан байдалтай байна. Засгийн газар нь, IX дүгээр зүйлд тусгагдсан ажилтнуудаас бусад, тус Улсын иргэншилтэй ажилтнуудад нэн чухал ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх зорилгоор үндэсний алба хаах үүргийг түр хойшлуулах эрхийг олгоно.
2. Байгууллагын дотоод статус болон эрх зүйн баримт бичгийн хүрээнд, ХХААБ нь Төлөөлөгчийн газарт ажилтан авах, ажиллуулах болон ажлын байрны нөхцөлийг тодорхойлно.

VI дугаар зүйл

Засгийн газрын хувь нэмэр

Засгийн газар ХХААБ-д энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хэлэлцээрийн хүчинтэй бүхий л хугацаанд төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд шаардлагатай барилга байгууламж, техник тоноглол, албан өрөөний тавилга болон бусад шаардлагатай байгууламжийг төлбөр хураамжгүйгээр ашиглуулах ба тэдгээрийг

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ 

2025 оны 08 сарын 12 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

ХХААБ хүлээн зөвшөөрнө. Тус байгууламжуудыг нь уг хэлэлцээрийн салшгүй хэсэг болох Хавсралтад тусгасан байна.

VII дугаар зүйл

ХХААБ-ын Өмч, Сан, Хөрөнгө

1. ХХААБ, түүний өмч, сан, хөрөнгө нь байршил ба эзэмшлээс үл хамааран хууль эрх зүйн бүх төрлийн ажиллагаанаас чөлөөлөгдөх дархан эрх эдлэх бөгөөд зөвхөн Ерөнхий захирал дархан эрхээсээ тусгайлан татгалзсан тохиолдолд тус эрх хасагдана. Гэхдээ дархан эрхээс татгалзах нь шийдвэр гүйцэтгэх арга хэмжээнд хамаарахгүй.

2. ХХААБ-ын барилга байгууламж, сан, хөрөнгө, түүний дотор архив, нь халдашгүй байна. ХХААБ-ын өмч, сан, хөрөнгийг байршил ба эзэмшлээс үл хамааран гүйцэтгэх, захиргаа, шүүх, хууль тогтоох үйл ажиллагааны хүрээнд нэгжих, албадан дайчлах, битүүмжлэх зэргээс чөлөөлнө. ХХААБ-ын барилга байгууламж нь харьяаллын гадна байх ба Суурин төлөөлөгч нь Ерөнхий захирлын төлөөлөгчийн хувиар бүрэн хянан удирдах эрхтэй.

3. ХХААБ, түүний хөрөнгө, сан, орлого болон бусад эд хөрөнгө, үүнд ХХААБ-ын үйлчилгээ үзүүлэгчдээс худалдан авсан бараа, үйлчилгээ дараах зүйлсээс чөлөөлөгдөнө:

а) Бүх төрлийн шууд болон шууд бусаар ногдуулсан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, төлбөр, замын хураамж, онцгой албан татвар болон төлбөрүүдээс чөлөөлөгдөнө; гэхдээ, ХХААБ Засгийн газраас буюу Засгийн газраас гаргасан журмын дагуу үйл ажиллагаа эрхэлдэг корпорацаас үзүүлсэн олон нийтийн үйлчилгээг тогтоосон хувиар төлөх ёстой төлбөр болох татвараас чөлөөлөхийг шаардахгүй бөгөөд эдгээр үйлчилгээг тусгайлан заан тодорхойлж, ангилсан байж болно. Энэхүү чөлөөлөлт нь үйл ажиллагаанд зориулан худалдан авсан бараа, тоног төхөөрөмж болон бусад материалд хамаарна.

б) ХХААБ нь албан хэрэгцээнд зориулан импортлох буюу экспортлох бараанд ногдуулах гаалийн татвар, хориг, хязгаарлалтаас чөлөөлөгдөнө, үүнд төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд шаардлагатай бараа, материалыг хамруулна. Гэвч, ийм чөлөөлөлттэйгөөр импортолсон бараануудыг, Засгийн газартай нөхцөлүүдийг харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд, тухайн Улсад зарж борлуулахгүй.

с) ХХААБ-ын хэвлэл нийтлэл, хөдөлгөөнт болон гэрэл зураг, дүрс бичлэг, дуу бичлэг нь хэмжээ, тоо болон хэлбэр (цахим эсхүл бусад)-ээсээ үл хамааран импортлох, экспортлохтой холбоотой гаалийн татвар, хориг, хязгаарлалтаас чөлөөлөгдөнө.

4. ХХААБ нь ямар ч санхүүгийн хяналт, журам, эсхүл түр хориггүйгээр:

а) Ямар ч төрлийн мөнгөн сан, үнэт цаас, валют болон хөрвөх чадвартай мөнгөн тэмдэгт худалдаж авах, эзэмших, ашиглах болон ямар ч валютын данс хөтөлж, үйл ажиллагаа явуулах эрхтэй байна;

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2015 оны 08 сарын 22 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

b) Өөрийн мөнгөн сан, үнэт цаас, валют болон хөрвөх чадвартай мөнгөн тэмдэгтийг нэг улсаас нөгөөд шилжүүлэх, эсхүл тухайн Улсын дотор шилжүүлэх эрхтэй бөгөөд эзэмшиж буй ямар ч валютыг өөр валют руу хөрвүүлэх эрхтэй байна.

5. ХХААБ санхүүгийн үйл ажиллагаа явуулахдаа хуулийн дагуу боломжит хамгийн таатай валютын ханшаар арилжих эрхтэй байна.

VIII дугаар зүйл

Харилцаа холбоо

1. ХХААБ-ын албан харилцаанд ашиглагдах шуудан, интернет үйлчилгээ, утас болон бусад бүх төрлийн харилцаа холбооны хэлбэрт, түүнчлэн хэвлэл, радиод мэдээлэл өгөхтэй холбогдох төлбөр, хураамжид Засгийн газраас Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад байгууллага, төрийн байгууллагууд, тэр дундаа Дипломат төлөөлөгчийн газарт олгодог нөхцөлөөс дутуугүй тааламжтай нөхцөлийг олгоно.

2. Засгийн газар ХХААБ-ын албан харилцаа, захидал харилцааны халдашгүй байдлыг хангах бөгөөд ямар нэгэн хязгаарлалт тавихгүй. Энэ халдашгүй байдал нь хэвлэл нийтлэл, хөдөлгөөнт болон гэрэл зураг, дүрс бичлэг, дуу бичлэг, тэдгээрийн хэмжээ, тоо, хэлбэрээс (цахим болон бусад) үл хамааран хамруулна.

3. ХХААБ нь харилцаа холбооны хэрэгслүүдийг ажиллуулах эрхтэй бөгөөд үүнд тусгай зөвшөөрлийн төлбөргүй цахим хэрэгслүүд, радио, сансрын хиймэл дагуулын байгууламж багтана. Түүнчлэн, код ашиглах, шуудангаар захидал илгээх, хүлээн авах эрхтэй бөгөөд тэдгээр нь дипломат төлөөлөгчийн газрын шуудантай адил дархан эрхтэй байна.

4. Энэ хэсгийг үл харгалзан, ХХААБ болон Засгийн газар хооронд нэмэлт гэрээгээр тодорхойлох аюулгүй байдлын зохих арга хэмжээ авахад саад болохгүй гэж үзнэ.

IX дүгээр зүйл

Ажилтнууд

1. ХХААБ-ын ажилтнууд дараах эрх ямба, дархан эрх, чөлөөлөлт болон нөхцөлүүдийг эдлэх эрхтэй:

a) Албан үүргээ гүйцэтгэх үедээ хэлсэн буюу бичсэн үг, хийсэн аливаа үйлдлийнхээ улмаас хуулийн хариуцлагад татагдахгүй. Энэхүү дархан эрх нь ХХААБ-ын ажлаа дуусгавар болгосны дараа ч хүчин төгөлдөр байна;

b) Ажилтнууд албан үүргээ гүйцэтгэх үедээ хэлсэн буюу бичсэн үг, хийсэн аливаа үйлдэлтэй холбоотой баривчлах, цагдан хорих үйл ажиллагаанаас чөлөөлөгдөнө;

c) Ажилтнууд нь албан үүргээ гүйцэтгэх үеийн ачаа тээш, тэдний албан хэрэгцээнд ашиглагддаг эд зүйлсийг, мөн хувийн тээш, эсхүл биедээ авч яваа эд зүйлсийг хянан шалгах, хураахаас дархан эрх эдэлнэ;



- d) ХХААБ-аас олгох цалин, урамшуулал болон бусад бүх төрлийн хөлсөд татвар төлөхөөс чөлөөлөгдөнө;
- e) Цэргийн албаны үүрэг, эсхүл албадан үйлчилгээний үүргээс чөлөөлөгдөнө;
- f) Эхнэр, нөхөр болон асрамжид нь байдаг төрөл садан нь харьяаттай холбоотой хязгаарлалт болон гадаад иргэнээр бүртгүүлэх шаардлагатай холбоотой дархан эрх эдэлнэ;
- g) Тус Улсад томилогдсон хугацаанд ажилтны эхнэр, нөхөр ба асрамжид нь байдаг төрөл садан, хэрэв ХХААБ тэдний статусыг хүлээн зөвшөөрсөн бол, ажил эрхлэлтийн зөвшөөрөл шаардахгүйгээр хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх эрхтэй;
- h) Тус Улсын Засгийн газрын дэргэд суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын харгалзах ижил түвшний ажилтнуудад олгодог хөнгөлөлтийг нэгэн адил эдэлнэ.
- i) Олон улсын хямралын үед Дипломат төлөөлөгчийн ижил түвшний ажилтнуудад үзүүлдэг хамгаалалт, нутаг буцаах тусламж үйлчилгээ нь ХХААБ-аас хүлээн зөвшөөрөгдсөн статус бүхий ХХААБ-ын ажилтнуудад, тэдний эхнэр, нөхөр болон асрамжид нь байдаг төрөл саданд адил хамаарна;
- j) Тус Улсад анх томилогдон ирээд гэрийн тавилга, хувийн эд зүйлсийг гаалийн татваргүй оруулах эрхтэй байна;
- k) Дипломат төлөөлөгчийн ижил түвшний ажилтнуудад баримталдаг Засгийн газрын журмын дагуу моторт тээврийн хэрэгслийг гаалийн татвар, онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татваргүй оруулах эрхтэй.
- l) Гадаад валют, гадаад валютын данс, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхтэй байх бөгөөд ХХААБ-тай ажилласан хугацаа дуусмагц хуулийн дагуу эзэмшиж байсан өөрийн хөрөнгийг тус Улсаас гаргах эрхтэй.

2. Дээрх 1 дэх хэсэгт дурдсан дархан эрх, эрх ямбаас гадна төлөөлөгч болон Р5 ба түүнээс дээш зэрэглэлийн ахлах ажилтнууд, тэдний эхнэр, нөхөр ба асрамжид нь байдаг төрөл садан нь олон улсын эрх зүйн дагуу дипломат төлөөлөгчийн байгууллагуудад олгодог эрх ямба, дархан эрх, чөлөөлөлт, нөхцөлүүдийг эдлэх эрхтэй байна. Энэ зорилгоор Монгол Улсын Гадаад харилцааны яам эдгээр хүмүүсийн нэрсийг дипломат жагсаалтад оруулна.

3. Тус Улсын иргэд, эсхүл байнгын оршин суугч ХХААБ-ын ажилтнууд зөвхөн энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн (a), (b), (c), (d), (e) дэд заалтуудад заасан эрх ямба, дархан эрх, чөлөөлөлт болон нөхцөлүүдийг эдлэх эрхтэй байна. Дэд хэсэг (c) нь зөвхөн тэдний албан ачаа тээшид үйлчилнэ.

Х дугаар зүйл

Алба гүйцэтгэгч мэргэжилтэн

Алба гүйцэтгэгч мэргэжилтнүүд албан томилгооны үед ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой хараат бус байдлыг хангахын тулд шаардлагатай эрх ямба, дархан эрхийг



олгоно, үүнд тэдний албан үүргийн хүрээнд замд аялах хугацаа орно. Алба гүйцэтгэгч мэргэжилтнүүд нь:

- a) Баривчлах, цагдан хорих, хувийн ачаа тээшийг хураах үйл ажиллагаанаас ангид байх дархан эрх эдэлнэ;
- b) Албан үүрэг гүйцэтгэх явцад хэлсэн буюу бичсэн үгс болон хийсэн үйлдлүүдийнхээ улмаас хуулийн хариуцлагад татагдахгүй. Хуулийн хариуцлагатай татагдахгүй байх дархан эрх нь ХХААБ болон холбогдох хороонд ажил үүрэг гүйцэтгэж дууссаны дараа ч үргэлжилнэ.
- c) ХХААБ-д гүйцэтгэсэн ажилтай холбогдолтой бүх дуу бичлэг, баримт бичиг, үүний дотор цахим харилцаа нь халдашгүй байна;
- d) ХХААБ-тай холбогдох зорилгоор код ашиглах, бичиг баримт, эсхүл захидлыг илгээмжээр, битүүмжилсэн уутанд, эсхүл цахим хэлбэрээр хүлээн авах эрхтэй;
- e) Гадаад засгийн газраас томилогдсон түр ажилтнуудтай олгодог ижил валютын болон арилжааны хязгаарлалтын боломжуудыг эдлэх эрхтэй;
- f) Дипломат төлөөлөгчдөд олгодог хувийн ачаа тээшний халдашгүй байдал болон бусад боломжуудыг адилхан эдлэх эрхтэй байна.

XI дүгээр зүйл

Нэвтрэх зөвшөөрөл

1. Засгийн газар ХХААБ-ын ажилтнуудад НҮБ-аас олгосон нэвтрэх зөвшөөрлийн баримт бичгийг (тусгай паспорт) зорчих хүчин төгөлдөр паспорттай эн тэнцүү болохыг хүлээн зөвшөөрнө. Шаардлагатай тохиолдолд НҮБ-ын тусгай паспорт эзэмшигчдийн визийн өргөдлийг аль болох шуурхай, үнэ төлбөргүй шийдвэрлэнэ.
2. Дээрх 1 дэх хэсэгт дурдсан эрхийг НҮБ-ын тусгай паспорт эзэмшдэггүй, ХХААБ-ын алба гүйцэтгэгч мэргэжилтнүүд болон ХХААБ-ын албан ажлын хүрээнд зорчсон гэдгийг гэрчилсэн бичиг баримттай бусад хүмүүст олгоно.

XII дугаар зүйл

Дамжин өнгөрөх, түр хугацаагаар оршин суух, хурал зөвлөгөөн зохион байгуулах, оролцох тухай

1. Энэхүү Хэлэлцээрт дурдагдсан иргэд, үүнд ХХААБ-ын зохион байгуулсан уулзалт, сургалт, семинар, чуулган болон ижил төстэй үйл ажиллагааны оролцогчид, тухайн улсад саадгүйгээр нэвтрэх, гарах, түр хугацаанд оршин суух, чөлөөтэй хөдөлгөөн хийх эрхтэй байна. Шаардлагатай гэж үзвэл, виз, эсхүл нэвтрэх, гарах зөвшөөрлийг аль болох шуурхай, үнэ төлбөргүй олгоно.
2. Засгийн газар нь ХХААБ-д тус Улсад хурал, уулзалт зохион байгуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. ХХААБ-аас зохион байгуулсан хурлын үеэр ~~Засгийн газар нь хэлэлцүүлэг,~~

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2015 оны 08 сарын 12 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

шийдвэр гаргалтын бүрэн эрх чөлөөг хангахад саад болох аливаа нөхцөл байдлыг үүсгэхгүй байхад бүхий л шаардлагатай арга хэмжээг авна. Засгийн газар нь эдгээр хурал, уулзалтад оролцож буй бүх төлөөлөгч, төлөөлөгчийн газрын ажилтан, шинжээч, ажиглагч болон ХХААБ-ын албан хаагчдад тэдний үүргээ бие даан хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх ямба, халдашгүй байдлыг олгоно. ХХААБ-ын Удирдах Зөвлөл, эсхүл хууль ёсны бусад байгууллагуудын хурал, уулзалт тус Улсад зохион байгуулагдах бол тусдаа гэрээгээр зохицуулагдана.

XIII дугаар зүйл

Нийгмийн хамгаалал

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тэтгэврийн сангаас олгож буй тэтгэмж нь аливаа татвараас чөлөөлөгдөнө.
2. ХХААБ болон Засгийн газар нь ХХААБ-ын ажилтнуудыг, иргэншил үл харгалзан, Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцооны хүрээнд заавал хамрагдах, албан журмын шимтгэл төлөх үүргээс чөлөөлөгдөнө гэдгийг зөвшөөрнө.
3. Энэ зүйлийн заалтууд нь хоёр дахь хэсэгт заасан ажилтнуудын гэр бүлийн гишүүдэд зохих ёсоор адил үйлчилнэ. Энэ тохиолдолд тэд Монгол Улсад хөдөлмөр эрхэлдэггүй, Монгол Улсаас нийгмийн даатгалын тэтгэмж хүртдэггүй байна.

XIV дүгээр зүйл

Эрх ямба, дархан эрхээс татгалзах тухай

1. Энэхүү Хэлэлцээрээр олгосон эрх ямба, дархан эрх, чөлөөлөлт, хөнгөлөлт нь зөвхөн ХХААБ-ын эрх ашгийн тулд олгогдсон бөгөөд холбогдох хүмүүсийн хувийн ашиг сонирхолд зориулагдаагүй болно. Ерөнхий захирал энэхүү Хэлэлцээрт заасан дархан эрх нь шүүхийн ажиллагаанд саад учруулж байна гэж үзвэл ХХААБ-ын эрх ашигт хохирол учруулалгүйгээр аливаа хувь хүний дархан эрхээс татгалзах эрх, үүрэгтэй байна. Гэхдээ дархан эрхээс татгалзах нь шийдвэр гүйцэтгэх арга хэмжээнд хамаарахгүй.
2. Энэхүү Хэлэлцээрээр олгосон дархан эрх, халдашгүй байдлыг үл хөндөж, эдгээр эрхийг эдэлж буй бүх этгээд нь тус Улсын хууль, тогтоомжийг хүндэтгэн мөрдөх, улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх үүрэгтэй.
3. ХХААБ нь энэхүү Хэлэлцээрээр олгогдсон эрх ямба, халдашгүй дархан эрх, хөнгөлөлтийг зүй бус ашиглахаас урьдчилан сэргийлэх, цагдаагийн дүрэм журмыг сахиулах, шүүн таслах ажиллагааг зохих ёсоор хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газартай бүхий л хугацаанд хамтран ажиллана.



XV дугаар зүйл

Хариуцлагаас чөлөөлөх тухай

Засгийн газар нь ХХААБ, түүний ажилтан болон ХХААБ-ын нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлж буй бусад хүмүүст гуравдагч этгээдээс гаргаж болзошгүй аливаа гомдол нэхэмжлэлийг шийдвэрлэх үүрэг хүлээж, ХХААБ-ын тус Улсад хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаас үүдэлтэй аливаа нэхэмжлэлд тус хүмүүсийг хариуцлагаас чөлөөлнө. Хэрэв тухайн нэхэмжлэл, эсхүл шаардлага дээр дурдсан хүмүүсийн ноцтой хайхрамжгүй үйлдэл, эсхүл санаатай буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж ХХААБ болон Засгийн газар харилцан зөвшөөрсөн тохиолдолд энэ заалт хамаарахгүй.

XVI дугаар зүйл

Нэмэлт хэлэлцээр

Засгийн газар болон ХХААБ нь энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэг буюу хэд хэдэн нэмэлт хэлэлцээр байгуулах боломжтой. Нэмэлт хэлэлцээрүүдэд Засгийн газар болон ХХААБ-ын харилцан тохиролцооны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

XVII дугаар зүйл

Маргаан шийдвэрлэх тухай

1. Энэхүү Хэлэлцээрт тусгагдаагүй аливаа асуудлыг Конвенцын дагуу, эсхүл олон улсын эрх зүйн ерөнхий зарчмуудын дагуу шийдвэрлэнэ.
2. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх, тайлбарлахтай холбоотой аливаа маргааныг яриа хэлэлцээний замаар шийдвэрлээгүй тохиолдолд, аль нэг талын хүсэлтээр арбитрын шүүхэд өгч болно. Арбитрын шүүх гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба нэг нь шүүхийн даргаар ажиллана. Засгийн газар болон ХХААБ тус бүр шүүхийн нэг гишүүнийг томилно; томилсон гишүүд харилцан зөвшөөрснөөр даргыг томилно. Даргыг томилоход зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд, Талуудын хүсэлтээр Олон улсын шүүхийн Ерөнхийлөгч шүүгчийг томилно. Арбитр нь ажиллах журмаа батлах бөгөөд гаргасан шийдвэр нь Талуудын заавал дагаж мөрдөх эцсийн шийдвэр болно.

XVIII дугаар зүйл

Төгсгөлийн заалтууд

1. Энэхүү Хэлэлцээрт Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, доор дурдсан 3 дахь хэсэгт дагуу дуусгавар болох хүртэл хүчинтэй хэвээр байна. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор тус Улс дахь төлөөлөлтэй холбоотой хүчин төгөлдөр бүх хэлэлцээрүүд хүчингүй болно.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2015 оны 08 сарын 12 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

2. Энэхүү Хэлэлцээрт ХХААБ болон Засгийн газар бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлтөд Засгийн газар гарын үсэг зурсан байна. Энэ хэлэлцээрт тусгагдаагүй холбогдох асуудлыг ХХААБ болон Засгийн газар хамтран шийдвэрлэнэ. Тал бүр санал солилцохдоо нөгөө Талаас энэ хэсгийн дагуу дэвшүүлсэн саналыг бүрэн харгалзан үзнэ.

3. Аль нэг Тал нөгөө Талдаа бичгээр мэдэгдэл өгч энэхүү Хэлэлцээрийг цуцлах ба тухайн мэдэгдлийг хүлээн авснаас хойш зургаан сарын дараа дуусгавар болно.

4. Энэхүү Хэлэлцээр дуусгавар болсон, эсхүл цуцлагдсан ч ХХААБ-ийн ажилтан, мөнгөн сан, өмч болон бусад хөрөнгийг зохистойгоор эргүүлэн татахад шаардагдах хугацааны туршид Талууд хүлээсэн үүргээ гүйцэтгэсээр байна.

ХЭЛЭЛЦЭЭРИЙГ БАТАЛГААЖУУЛЖ Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч болон ХХААБ-аас томилогдсон төлөөлөгч нар англи хэлээрх тус бүр 2 хувь үйлдсэн энэхүү Хэлэлцээртонысарын..... өдөр гарын үсэг зурав.

Монгол Улсын Засгийн газрыг
төлөөлж:

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн
байгууллагыг төлөөлж:

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

20... оны ... сарын ... өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ХХААБ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАРТ
ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР**

1. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү хавсралтын заалтууд нь Монгол Улс дахь төлөөллийн тусгай хэрэгцээ, ажилтнуудын тоо болон орон нутгийн нөхцөл байдлаас хамаарч өөрчлөгдөх боломжтой бөгөөд эдгээр шаардлагыг тогтмол хянаж, шаардлагатай үед өөрчлөлт оруулна.

1.2. Олгогдсон барилга байгууламж нь ХХААБ-ын Барилга зохион байгуулалтын удирдамжтай нийцэх ёстой ба хөгжлийн бэрхшээлттэй иргэдэд ээлтэй, саадгүй нэвтрэх байдлыг хангана.

1.3. Засгийн газрын зөвлөмжийн дагуу ХХААБ нь НҮБ-ын нэгдсэн барилгад байрлах тохиолдолд:

1.3.1. Энэхүү хавсралтын заалтууд үйлчлэхгүй байж болох бөгөөд НҮБ болон хүлээн авагч улс хоорондын тусдаа гэрээгээр зохицуулагдана;

1.3.2. Аль ч тохиолдолд Засгийн газар барилга, байгууламжтай холбоотой ХХААБ-д гарах бүх төрлийн зардлыг хариуцаж, тус улс дахь Төлөөлөгчийн газрын төсөвт хүндрэл учруулах нөхцөл байдлыг бий болгохгүй байна. Үүнд нүүлтийн зардал, үндсэн хөрөнгийн зардал, урсгал зардал зэрэг байгууламжтай холбоотой бүх зардал багтана.

2. Барилга, албан газар

2.1. Монгол Улсын Засгийн газар нь Төлөөлөгчийн газрын хэрэгцээнд нийцэх зохих тавилгатай барилга, байгууламжаар үнэ төлбөргүй хангах үүрэгтэй. Засгийн газрын санхүүжилттэй ХХААБ-ын худалдан авалтаар, эсхүл шууд хангамжаар тус барилга байгууламжид, шаардлагатай гэж үзвэл, зохих засвар, тохижуулалтыг хийх ба дараах үзүүлэлтүүдийг хангана:

2.1.1. Барилга, байгууламж:

2.1.1.1. Ажилтнууд, үүний дотор богино хугацааны зөвлөхүүдийн ажлын өрөө тасалгаа (хамгийн багадаа 12 өрөө);

2.1.1.2. Цахим мэдээллийн тоног төхөөрөмж байршуулах аюулгүй өрөө тасалгаа;

2.1.1.3. Гучин хүний багтаамж бүхий хурлын өрөө;

2.1.1.4. 30 м² хэмжээтэй агуулах;

2.1.1.5. Угталтын хэсэг;

2.1.1.6. Харуул, хамгаалалтын зай талбай;

2.1.1.7. Ажилтнуудад хүрэлцэхүйц ариун цэврийн өрөө (хамгийн багадаа 70 хүн);

2.1.1.8. 2 автомашины гарааж;

2.1.1.9. 10 автомашины зогсоол; болон

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

20... оны ... сарын ... өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

2.1.1.10. Амралт, цайны өрөө.

2.1.2. Б. Тоног төхөөрөмж ба тавилга :

2.1.2.1. ХХААБ-ын тодорхойлсны дагуу хамгийн багадаа 70 хүний ажлын өрөөний тавилга (ширээ, сандал, шүүгээ, тавиур), уулзалтын өрөөний тавилга, цайны өрөөний тавилга;

2.1.2.2. ХХААБ-аас тогтоосон техникийн шаардлагад нийцсэн мэдээллийн технологийн дэд бүтэц, тоног төхөөрөмж, үүнд хамгийн ихдээ арван компьютер, дэлгэц, гурван принтер, видео хурлын тоног төхөөрөмж зэрэг бусад шаардлагатай ажлын хэрэгслүүд

2.1.2.3. ХХААБ-аас тогтоосон техникийн шаардлагад нийцсэн интернэт сүлжээ, цахим харилцаа холбооны хэрэгслээр хангах;

2.1.2.4. ХХААБ-аас тогтоосон техникийн шаардлагад нийцсэн өндөр хүчин чадалтай хувилагч төхөөрөмж;

2.1.2.5. Худалдан авалтын давуу нөхцөлтэй холбоотойгоор Засгийн газрын санхүүжилтээр ХХААБ дээр дурдсан тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авах боломжтой;

2.1.2.6. ХХААБ-аас тогтоосон техникийн шаардлагад нийцсэн хоёр тээврийн хэрэгсэл; болон

2.1.2.7. ХХААБ-аас тогтоосон техникийн шаардлагад нийцсэн агааржуулалт болон халаалтын систем.

2.2. Хоёр талын харилцан тохиролцоонд үндэслэн Монгол Улсын Засгийн газар нь шаардлагатай засварыг хийх буюу санхүүжүүлэх үүрэгтэй.

2.3. Харилцан тохиролцсон байгууламжуудыг энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 сарын дотор ХХААБ ашиглахад бэлэн болгосон байна.

2.4. НҮБ-ын Аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын баримт бичгийг бүрэн дагаж мөрдөж албан газрын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна. Тус баримт бичигт өөрчлөлт орсоныг мэдсэн даруйд Засгийн газарт мэдээлнэ. Засгийн газар нь тус стандартын нийцлийг хангах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүй байдлын албанаас өгсөн аливаа зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

3. Үйл ажиллагааны жилийн зардал

3.1. Төлөөлөгчийн газрын тасралтгүй үйл ажиллагааг хангах үүднээс Засгийн газар жил бүр 100,000 ам.доллар, эсхүл үүнтэй дүйцэхүйц одоогийн НҮБ-ийн ханшаар тооцсон орон нутгийн валютаар мөнгөн хандив өгөхийг зөвшөөрнө. Энэ хөрөнгө оруулалт нь Төлөөлөгчийн газар болон түүний үйл ажиллагааны зардал, албан газрын тоног төхөөрөмж, таван жилээс удаан ашиглагдсан тээврийн хэрэгслийг солих зардалд зарцуулагдана. Энэ хувь нэмэр нь үйл ажиллагааны шаардлага, амьжиргааны зардалд гарсан өөрчлөлттэй уялдан тогтмол, харилцан зөвшилцсөний үндсэн дээр шинэчлэгдэнэ.

4. Албан хаагчид

4.1. Засгийн газар дараах зургаан техникийн, удирдлагын болон үйл ажиллагааны албан хаагчдад, эсхүл тус үүрэг ажилд хэрэгтэй санхүүжилтийг олгох бөгөөд цалин хөлс, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал болон бусад зардлуудыг хариуцна:



Нарийн бичиг;
Захиргааны ажилтан;
Хөтөлбөрийн ажилтан;
Жолооч;
Хоёр ахлах техникийн мэргэжилтэн.

4.2. Албан хаагчдыг тус Улсын төрийн албанаас хоёр жилийн хугацаатай сэлгэн томилж, гэрээг дахин хоёр жилээр сунгаж болно;

4.3. Техникийн, захиргааны болон үйл ажиллагааны албан хаагчдын цалин хөлс болон холбогдох бусад бүх нэмэгдлийг Засгийн газар хариуцан олгох бөгөөд эдгээр албан хаагчид нь холбогдох ХХААБ-ын ажлын нөхцөл, журмын дагуу энэ ангиллын ажилчдад олгогддог тусгай нөхөн олговрыг авах эрхтэй байна.

4.4. ХХААБ нь дээрх албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг Засгийн газарт хүргүүлнэ. Үүний үндсэн дээр Засгийн газар гурван нэр дэвшигчийг санал болгож, ХХААБ нь тэдгээрээс шаардлагатай шалгуурыг хангасан нэг нэр дэвшигчийг сонгоно. Нарийн бичгийн албан тушаалын хувьд ХХААБ нь шаардлагатай шалгалтуудыг зохион байгуулна.

4.5. Тус Улсын холбогдох байгууллагуудын техникийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх зорилгоор ХХААБ нь Засгийн газраас үндэсний залуу техникийн ажилтнуудыг хүлээн авч, ХХААБ-ын олон улсын шинжээчидтэй хамтран ажиллах боломжийг олгоно. Эдгээр ажилтнуудын цалин хөлс, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад холбогдох зардлыг Засгийн газар үргэлжлүүлэн хариуцах бөгөөд техникийн багийн хамтын ажиллагаа, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор нэмэлт дэмжлэг үзүүлж болно.

4.6. Энэ Хавсралтын хүрээнд Засгийн газраас томилогдсон үндэсний албан хаагчид нь энэхүү Хэлэлцээрийн дагуу албан үүргээ гүйцэтгэх явцад хэлсэн буюу бичсэн үг, хийсэн үйлдлүүдийнхээ улмаас хуулийн хариуцлагад татагдахгүй. Энэхүү дархан эрх нь тухайн албан хаагчид ХХААБ-ын албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа ч үргэлжлэх болно. Мөн тэдний ХХААБ-ын үйл ажиллагаатай холбоотой боловсруулсан бичиг баримт, материал халдашгүй байна.

5. Стратегийн хувь нэмэр, дэмжлэг

5.1. Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээс гадна, ХХААБ болон Засгийн газрын хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээ, 2030 Хөгжлийн Хөтөлбөрийн зорилтуудыг хангахад чиглэсэн хамтын үйл ажиллагааг Засгийн газар дэмжиж, нэмэлт санхүүжилт олгох боломжтой. Энэ нь дараах чиглэлүүдийн санхүүжилт байж болно (дор дурдсан зүйлсээр хязгаарлагдахгүй):

5.1.1. Үндэсний зөвлөх, мэргэжилтэн, албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх сургалт, арга хэмжээ;



5.1.2. ХХААБ-ын стратегийн зорилгууд, Хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээд тусгагдсан үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй нийцсэн тусгай төслүүд, санаачилгыг боловсруулах, хэрэгжүүлэх;

5.1.3. Үйл ажиллагааны үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор дэд бүтэц, технологийн нөөцийг сайжруулах;

5.1.4. Тус улсад ХХААБ-ын эрхэм зорилго, зорилтуудыг сурталчлах олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих.

5.2. Засгийн газраас олгох нэмэлт дэмжлэгийг Төлөөлөгчийн газрын хувьсан өөрчлөгдөх хэрэгцээ, тэргүүлэх чиглэлүүд, үндэсний хөгжлийн зорилтууд, Хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээ, болон НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээтэй нийцүүлэх үүднээс тогтмол харилцан зөвшилцөж, хянан тохиролцоно.

6. Хянах, тохируулах тухай

6.1. Энэхүү Хавсралтад заасан нөхцөлүүдийг Монгол Улс дахь ХХААБ-ын Төлөөлөгчийн газрын хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор ХХААБ болон Засгийн газар харилцан тохиролцож, тогтмол хянан шалгаж, шаардлагатай тохируулгыг хийнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/

2025 оны 08 сарын 12-нд
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION